



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 4/23

Эрдэнэт

**Мал, амьтны сэг зэм устгал
халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дах заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 4.1, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 02 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2024 оны "Мал, амьтны сэг зэм устгал халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах тухай" А/122 дугаар захирамжийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн, малын гоц халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлж, өвөлжилтийн хүндрэл зудын улмаас хорогдсон мал амьтны сэг зэмийг устгах, бэлчээр бууц хашаа хороо, зоорь агуулах уст цэг усны эх булгийг цэвэрлэх халдваргүйтгэлийн ажлыг 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Сэг зэм устгал, мал эмнэлэг ариун цэвэр ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар, зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Гэрээгээр гүйцэтгэх ажлыг чанартай зохион байгуулж, багийнхаа нутаг дэвсгэрт үхсэн малын сэг зэмийг зааврын дагуу устган ариутгал халдваргүйтгэл хийхийг "Шинэ Чандмань ХХК (Б.Давхарбаяр), Дөрөлжин даваа ББН (О.Эрдэнэцэцэг), Бүгдгээн нутаг ХХК (А.Хүрэлбаатар) нарт мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангаж хяналт тавьж, үр дүнг тооцож тайлан мэдээг холбогдох газар хүргүүлж ажиллахыг тархвар зүйч (Б.Жамбалдорж)-д үүрэг болгосугай.

4. Хүн амыг мэдээллээр хангаж халдварт болон паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг сумын Засаг даргад 05 дугаар сарын 27-ны дотор танилцуулахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Б.Лаагансүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАТ-ЭРДЭНЭ



Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын
Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны
өдрийн А/23 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



**СЭГ ЗЭМ УСТГАЛ, АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лаагансүрэн (Мал эмнэлгийн тасгийн дарга, Улсын байцаагч)

Гишүүд: Б.Давхарбаяр (Шинэ чандмань ХХК-ны захирал)
О.Эрдэнэцэцэг (Дөрөлжин даваа ББН захирал)
А.Хүрэлбаатар (Бүгдгээн нутаг ХХК-ны захирал)
Т.Болдбаатар (1 дүгээр багийн Засаг дарга)
Г.Билэгдэмбэрэл (2 дугаар багийн Засаг дарга)
Х.Даш-очир (3 дугаар багийн Засаг дарга)
Б.Одхүү (4 дүгээр багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Жамбалдорж (Тархвар зүйч)

-----oOo-----

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын
Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны
өдрийн А/23 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ, ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ
ХҮЛЭЭЖ АВАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: С.Баянмөнх (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Заяабаяр (Санхүү албаны дарга)

Б.Лаагансүрэн (Мал эмнэлгийн Улсын байцаагч)

Э.Хүрэлбаатар (Байгаль хамгаалагч)

Ц.Нандмаа (Цаг уурын өртөөний дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Бат-Амгалан (Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

-----oOo-----

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын
Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны
өдрийн А/23 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР СУМЫН ҮХСЭН МАЛЫН СЭГ ЗЭМ УСТГАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

1. "Хамтрахгүй бол барахгүй" үхсэн малын сэг зэмийг устгах 10 хоногийн аяны хүрээнд зарцуулагдах бензин түлшний 20,000,000 (хоёр сая) төгрөгийн зардал нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд зарцуулагдана.

Шинэ-Идэр сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс:

1. Ариутгал халдваргүйтгэл хийх ариутгалын бодис 3,000,000 (гурван сая) төгрөг
2. Зам дагуу хоцрогдсон сэг зэмийг цуглуулж устгах зардал 1,000,000 (нэг сая) төгрөг
3. Халдвар хамгааллын хувцас хэрэгсэл 500,000 (таван зуун мянга) төгрөг
4. Хоол ундны зардал 500,000 (таван зуун мянга) төгрөг

-----oOo-----